

ТАТВАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРОЛЦОО

Х. Тунгалагмаа, Ц.Мишигдорж, Л.Бат-Өлзий

“Монголтакс ТМЗ” ХХК

Товч танилцуулга: Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний чиг хандлага, олон улсын туршлагаудыг судлан, татвар төлөгчдийн татвар төлөх нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд татварын үйл ажиллагаан дахь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний оролцоог тодорхойлон, санал зөвлөмж боловсруулав. **Түлхүүр үг:** Татвар төлөгч, Татварын алба, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ (ТМЗҮ) , Нийгмийн сэтгэлзүй

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ (ТМЗҮ) нь сүүлийн жилүүдэд олон улс оронд идэвхтэй хөгжиж буй салбар юм. Манай улсад анх 2004 онд ТИНЗ нийгэмлэг байгуулагдсанаар энэхүү үйлчилгээг хөгжүүлэх суурь алхам бүрдсэн. Олон улсын туршлагаас харахад сүүлийн жилүүдэд татварын үйл ажиллагаанд төр болон татвар төлөгч гэсэн үндсэн субьектээс гадна татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний (итгэмжлэгдсэн этгээд) үүрэг нэмэгдэж байна. Энэхүү гурвалсан харилцаа бүхий татварын үйл ажиллагаа нь татварын албаны ачааллыг бууруулах, татвар хураалтын үр ашгийг нэмэгдүүлэх, татвар төлөгчдийг эрсдэлээс хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймд ихэнх улс орнууд татвар, нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн зөвлөх байгууллагуудын үйлчилгээний онцлогтой төр засгийн бодлогоо хослуулах замаар тэдний үйл ажиллагааг дэмждэг. Энэ нь татварын хуулийг сурталчлан таниулах гол суваг болж байгаатай холбоотой юм. Мөн ТМЗҮ-г дэмжих замаар хамтран ажиллаж буй улсуудын хувьд татвар төлөгч нь татвараа өөрөө тодорхойлж төлөх нийгэм-сэтгэл зүйн төлөвшил бүрдэж, ТМЗҮ-гээр дамжуулан өөрсдийн санхүү, татварын итгэмжлэгдсэн төлөөллийн тайлагналыг өдөр тутмынхаа баталгаат үйлчилгээ болгон үйлчлүүлж хэвшсэн байна. Иймд Монгол улсын татварын үйл ажиллагаанд ТМЗҮ-ний оролцоог нэмэгдүүлэх замаар татвар төлөгчдийн татвар төлөх нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэх боломжийг судлахад энэхүү судалгааны ажил чиглэгдсэн.

I. ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Татварын зөвлөх үйлчилгээний эхлэлийг анх 1884 онд Америкийн мэргэшсэн төлөөллийн систем тавьсан гэж үздэг. 1950-1960-аад оноос хойш барууны хөгжингүй орнуудаас гадна хөгжиж буй олон улс орнууд ч энэхүү төлөөллийн системийг дэлгэрүүлж эхэлсэн. Одоогийн байдлаар Япон, Герман, Солонгос, Америк, Англи, Австрали, Канад зэрэг орнууд бүгд татварын зуучлалын системийг хэрэгжүүлж байна. Татварын зөвлөх үйлчилгээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, улам боловсронгуй болсноор улс орны албан татвар ногдуулалтад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Татварын зөвлөх үйлчилгээний хөгжлийн үйл явцыг гурван үе шатанд хувааж болно.

Нэгдүгээр үе шат: 1886 онд Их Британи улсад бий болсон. Анхны татварын зөвлөх үйлчилгээг “Хенри нягтлан бодогч фирм”-ээс дэлхийн хоёрдугаар дайны өмнөх үеийг хамааруулдаг байна. Энэ үед татварын зөвлөх үйлчилгээний хүрээ нь бага, зөвхөн орлогын албан татвар, борлуулалтын татвар, татвар хэрхэн төлөх талаарх зөвлөгөөгөөр хязгаарлагддаг байжээ. Зөвлөгөөг ихэвчлэн засгийн газрын санхүү, татварын албанаас гарсан хүмүүс өгдөг байна.

Хоёрдугаар үе шат: Дэлхийн хоёрдугаар дайнаас 1960-аад он хүртэлх хугацааг хамааруулан үздэг. Энэ үед татварын зөвлөх үйлчилгээний хүрээ тэлж эхэлсэн төдийгүй орлогын албан татвар, борлуулалтын татвараас гадна НӨАТ, НДШ, өв залгамжлалын татваруудыг хамрах болсон. Зарим хөгжингүй орнуудад татварын тайланг тушаах систем бий болсноор зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд татварын тайланг бөглөх тухай зөвлөгөө өгдөг болжээ. Зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага нь татварын албаны албан ёсны болон хувийн чөлөөт мэргэжилтнүүд гэсэн 2 хэлбэртэй байна. Мөн цогц татварын тогтолцооны хэрэгжилт, хураалт нь илүү горимтой болж, хуулинд татварын албыг татвар төлөгчдөд төрийн бодлогыг тайлбарлах, татварын хуулийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, татвар төлөгчдийг татвар төлөх үүргээ зөв биелүүлэх зэргийг шаардах үүрэгтэй гэж заажээ. Улмаар нийгэмд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийг тусгайлсан салбар болгон зохион байгуулалттайгаар хөгжүүлж эхэлсэн.

Гуравдугаар үе шат: 1960 - аад оноос одоог хүртэлх хугацааг хамааруулан үздэг. Энэ үед зах зээлийн эдийн засгийн тасралтгүй хөгжлийг даган хувийн хэвшлийн татварын зөвлөх үйлчилгээ өргөжиж, татварын албаны зөвлөх үйлчилгээний үндсэн чиглэл нь татварын бодлого, хууль тогтоомж болон хураан авах зэргээр хязгаарлагдсан байна. Одоогоор татварын зөвлөх үйлчилгээг ерөнхийд нь 3 төрөлд хуваан үздэг байна¹.

¹ 涉税服务在世界各国的发展, 中国税务报·祝穗观

Төвлөрсөн хэлбэр. Энэ хэлбэрийн улс орнууд нь тусгай хууль, удирдах байгууллагатай байдаг. Мөн татварын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хүмүүст тусгайлсан мэргэжлийн өндөр шаардлага тавьдаг ба мэргэшсэн болохын тулд засгийн газраас зохион байгуулдаг шалгалтад орж эрх авдаг байна. Жишээ нь Япон, Солонгос, Герман улсууд гэх мэт.

Чөлөөт хэлбэр. Улс орон нь татварын зөвлөх үйлчилгээнд анхаарал бага хандуулдаг. Мөн тусгай хууль, удирдах байгууллага байдаггүй бөгөөд зөвхөн бүртгүүлээд үйл ажиллагаагаа эхлүүлдэг. Тиймээс ихэвчлэн татварын зөвлөх үйлчилгээг мэргэшсэн нягтлан бодогч, хуульч хийх зөвшөөрөлтэй мэргэжлийн хүмүүс хүргэдэг байна. Энэхүү зөвшөөрлийг салбарын байгууллага, мэргэжлийн олон нийтийн төлөөлөл бүхий нийгэмлэг нь үнэлж өгдөг. Жишээ нь: Австрали, Франц, Голланд, Бельги улсууд гэх мэт.

Холимог хэлбэр. Нэг талаас тусгайлсан хууль, удирдах байгууллагатай байх, нөгөө талаас татварын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн хүмүүс нь хуульч, мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн төлөөлөгч зэрэг байдаг байна. Хэдийгээр тусгайлсан хуультай боловч төвлөрсөн хэлбэртэй харьцуулахад төрийн зүгээс анхаарал хандуулах нь бага байдаг. Мэргэшсэн төлөөлөгч нь шалгалтаар эсвэл бүртгүүлж мэргэжлийн эрхээ авдаг. Жишээ нь Англи, Америк улсууд гэх мэт.

II. ТАТВАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХАРИЛЦАА)

Татварын үйл ажиллагаа нь төр татвараа хураан авах, татвар төлөгч нь өөрт ногдох татвараа төлөх “үндсэн харилцаа”²-аас гадна татварын зохицуулалт, хяналтын үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийгэм эдийн засгийн бүхий л хүрээнд явагддаг. Энэхүү үйл ажиллагаанд төр болон татвар төлөгч нь гол субъект юм. Төрийн төсвийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нийгэм эдийн засгийн тэнцвэрийг хангах бодлого нь татварын механизмаар хэрэгжиж, татварын үйл ажиллагаанд биеллээ олдог байна. Татвар төлөгч нь татварын хууль хэрэгжүүлэгч бөгөөд үнэнч шударгаар бодит мэдээллээр хангах, бүртгэл хөтлөх, татварын өр төлбөрийг төлөх үүрэгтэй.³ Татварын алба нь төрийн гүйцэтгэх алба буюу татварын хуулийн хэрэгжилтийг хангах төсвийн татварын орлогыг бүрдүүлэгч нь байдаг.

Дэлхийн ихэнх орнууд *татвараа өөрөө тодорхойлон төлөх системийг* хэрэглэдэг ба энэ нь татварын албаны үйл ажиллагаа үр ашигтай байх зарчимтай уялддаг. Татвараа

² OECD Tax Intermediaries Study Working Paper 6 – The Enhanced Relationship

³ Organization for Economic Co-operation and Development (OECD), Taxpayers’ Rights and Obligations—Practice Note (2001).

өөрөө тодорхойлох тогтолцоо нь нэг талаас татвар төлөх ардчилсан үзэл санаанд нийцдэг бөгөөд нөгөө талаас татвар хураалтын төрийн зардлыг багасгах, бага зардлаар их татвар хураах шаардлагад нийцдэг. Энэ нь *татвар төлөгчдөөс* дараах 3 үүргийг шаарддаг. Үүнд:

- I. татвар ногдуулах орлогоо зөв тооцож, тодорхойлох;
- II. тайлангаа тогтоосон хугацаанд нь гаргаж тушаах;
- III. татвараа хугацаанд нь бүрэн төлөх.

Татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтийг хангахад дараах 6 нөхцөлийг *төрийн зүгээс* бүрдүүлэхийг шаарддаг байна⁴. Үүнд:

- хуулийн тогтоомжийн заалтууд ойлгомжтой, тодорхой байх;
- татварын алба нь татвар төлөгчдөдөө үйлчилгээ үзүүлдэг алба байх;
- татвар төлөгчийг бүртгэх, тайлан авах, буцаан олголт хийх үйл ажиллагаа хөнгөн шуурхай зохион байгуулагдсан байх;
- татвар төлөгч үүргээ хэрэгжүүлэхээс өөр гарцгүй байх хураалтын хүчтэй механизм үйлчлэх;
- хариуцлага хүлээхээс өөр хяналтын тогтолцоотой байх;
- төр, татвар төлөгчдөд туслалцаа үзүүлдэг үйлчилгээний тогтолцоотой байна.


Татвар төлөгч нь өөрийн явуулж байгаа үйл ажиллагаанаас ямар хэмжээний орлого олж байгаа, түүнийг олохтой холбогдуулан ямар хэмжээний зардал гарч байгааг баримтжуулан бүртгэж татварын албанд тайлагнах үүрэгтэй. Гэвч татвар төлөгчдийн дийлэнх нь энэ үүргээ хэрэгжүүлэхийг мэддэггүй, тайлан бүртгэлийн ач холбогдлыг төдийлөн ойшоодоггүй байдлаас татварын хяналт шалгалтад ямар нэгэн зөрчил илэрдэг. Мөн татварын хууль нь олон төрлөөс бүрддэг ба тэдгээртэй холбоотой тогтоол, дүрэм, аргачлалын талаар татвар төлөгчийн ойлголт хангалтгүй, татвараа тодорхойлж төлөх арга зүй эзэмшээгүй байдаг нь татварын хураалтад бэрхшээл учруулдаг.

Дэлхийн улс орнуудад татвар хураалтын үр ашгийг нэмэгдүүлэх, татвар төлөгчийн эрсдэлийг бууруулах зорилгоор татварын зөвлөх үйлчилгээг татварын тогтолцоонд чухалчлан үздэг. Энэ нь татварын алба, татвар төлөгчөөс гадна итгэмжлэгдсэн мэргэшсэн этгээдийн оролцоог нэмэгдүүлэн татвар үйл ажиллагааг улам боловсронгуй болгож байна. Тиймээс судалгааны хүрээнд гадаадын улс орнуудын татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ нь татварын үйл ажиллагаанд ямар оролцоотой байдгийг

⁴ Г.Алтанзаяа, Татвар хураах механизм, Бодлогын судалгаа- 2007

судалснаар манай улсын хувьд олон улсын туршлагаас өөрсдийн онцлогт тохирсон цаашдын чиг баримжааг тодорхойлох боломжтой болох юм.

Зураг 1: Татварын үйл ажиллагааны (харилцааны) уялдаа



Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний татварын систем дэх үүргийн тухай ойлголт: (Roman Tomasic, 1990)

1. Татварын алба ба татвар төлөгчийн хоорондын зуучлагч:
 - Татварын хуулийг ойлгомжтой хэлбэрт оруулан татвар төлөгчид тайлбарлах
 - Татварын институт зэргээр дамжуулан татварын албатай холбогдох асуудал дээр санал өгөх
2. Дагаж мөрдөхийг зөвлөх-compliance advisers: Татварын эрсдэлээс хамгаалахын тулд татварын хуулийг дагаж мөрдөхийг зөвлөдөг.
3. Татварын систем дэх нөлөөлөгч: нэг талаас татвар төлөөлөгчийг хуулийг хэрэгжүүлэхэд, нөгөө талаас татварын хууль болон хэрэгжүүлэлтэнд санал оруулах

III. БУСАД УЛС ОРНУУД ДАХ ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУРШЛАГААС

Япон улсын татвар төлөгчийн 85 хувь нь татварын зөвлөхөөр үйлчлүүлдэг.⁵

Япон улс нь 1942 онд “Татварын төлөөллийн хууль”-ийг боловсруулсан. 1951 онд ААНОАТ, ХХОАТ, өв залгамжлалын татвар зэрэг татвар төлөх шаардлагад нийцүүлэхийн тулд “Татварын төлөөллийн хууль”-ийн үндсэн дээр “Татварын итгэмжлэгдсэн зөвлөх (ТИЗ) хууль”-ийг боловсруулсан бөгөөд холбогдох шалгалтын

⁵ <http://www.chinaacc.com/new/253/260/2006/2/ma925645852142260023996-0.htm>

системийг бий болгосон. Ингэснээр ТИЗ-н үйлчилгээний хүрээ өргөжиж, татварын зөвлөх үйлчилгээ хурдтай хөгжихөд дэмжлэг болсон байна.

Япон улсын ТИЗ нь татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Япон улсын татварын хууль болон холбогдох хууль тогтоомж нь маш нарийн төвөгтэй байдаг учраас татвар төлөгч нь мэргэжлийн мэдлэг хангалтгүй бол үнэн зөвөөр ойлгоход хүндрэлтэй байдаг. Харин нь ТИЗ эдгээр иргэдэд татварын зөвлөгөө үзүүлэх, татварын тайланг төлөөлөн тушаах зэрэг үйлчилгээг үзүүлдэг. Ингэснээр улсын татварын бодлого амжилттай хэрэгжихэд тус дэм болдог байна.

ТИЗ оролцсоноор нэг талаас татвар төлөгчийг татварын хуулийн дагуу татвар төлөхөд туслах, нөгөө талаас татварын ажилтны ажлыг хөнгөвчлөх, татвар хураах зардлыг бууруулж байна.

ТИЗ систем хэрэгжсэнээр Япон улсыг дэлхий дээрх татварын зардал хамгийн багатай улс болгосон. Мөн татварын ажилтан бүрт ноогдох татвар хураалтын хэмжээ хамгийн өндөр орон юм. Япон улсад бизнесийн байгууллагын 85 хувь нь ТИЗ фирмээр татварын үйл ажиллагаагаа даатган, үйлчилгээ авдаг байна. Токио хотын хувьд бизнесийн байгууллагуудын 96 хувь нь ТИЗ фирмээр үйлчлүүлдэг.

Япон улсын татварын төлөөллийн үйлчилгээний онцлог:

1. *Хууль эрх зүйн үндэс нь боловсронгуй төгс:* Япон улсын “ТИЗ хууль” нь 1942 онд албан ёсоор бий болсноос хойш 1990-ээд оны дунд хүртэл том жижиг 20 гаруй удаагийн засварт орсон, ТИЗ систем хатуу чанд хэм хэмжээг бий болгосон. “ТИЗ-ийн хууль” нь Япон улсын ТИЗ системд гол байр суурийг эзэлдэг бөгөөд Япон улсын ТИЗ системийн хөгжлийн гол суурь нь гэж үздэг.
2. *Нэмэлт хуулийн заалт бүрэн бүтэн байдал:* Япон улс нь ТИЗ-ийн үйл ажиллагааны хамрах хүрээ, цалин хөлс, эрх үүргийн тухай тодорхой заалт, татварын төлөөллийн үйлчилгээний норм, тогтвортой хөгжлийг дэмжих тухай олон тооны дүрэм заалтууд байдаг.
3. *Зохион байгуулалт менежмент хатуу чанд эмх цэгцтэй:*
 - *Хатуу чанд ТИЗ-ийн мэргэжлийн хяналт ба шалгалтын систем:* Япон улс нь ТИЗ-ийн шалгалтад орж байгаа хүмүүсээс авч байгаа мэргэшлийн шалгалт хатуу чанд байдаг. Жишээ нь шалгалтаас чөлөөлөгдөх татварын ажилтан нь татварын хэлтэс, дүүргийн татварын газар, улсын татварын албанд 23-аас дээш жил ажилласан байх, мөн албан ёсоор боловсруулсан хичээлийг заавал үзэж дуусгах ёстой гэсэн хатуу нөхцөлтэй байдаг.

- *Дотоод гадаад хоёр удирдлагын системд харилцан шударга хязгаарлалт хийх:* Япон улсын ТИЗ-ийн хяналт нь дотоод хяналт ба гадаад хяналт гэсэн 2 багц менежментийн системтэй. Салбарын дотоод хяналт нь улс даяараа Япон улсын ТИЗ холбоогоороо дамжиж хэрэгждэг. Холбоо нь улсын татварын албаны 14 дүүрэгт ТИЗ нийгэмлэг байгуулсан, ТИЗ болгон заавал өөрийн дүүргийн ТИЗ нийгэмлэгт орох ёстой ба “Япон улсын ТИЗ холбооны дүрэм”-г дагаж мөрдөх ёстой. Гадаад хяналт нь Япон улсын засгийн газраас хэрэгжүүлдэг хяналтыг хэлнэ. Сангийн яам, улсын татварын алба нь ТИЗ хяналтын нийгэмлэгийг зохион байгуулдаг. Энэ нь улс орон даяарх ТИЗ-ийн мэргэшлийн хяналт, шалгалт болон шагнал шийтгэл зэргийг хариуцдаг байна. Сангийн яамнаас ТИЗ холбоо болон нийгэмлэгт хяналт шалгалт явуулж тайлан өгөхийг шаарддаг. Энэхүү дотоод гадаад нийлсэн давхар хяналтын системээр дамжуулан татварын төлөөллийн бодит шударга байдлыг хангаж байна.
- 4. *ТИЗ үйлчилгээ нь өндөр чанартай:* Япон улсын ТИЗ нь бүгд хатуу чанд мэргэшлийн шалгалт өгч бүртгүүлдэг учир татварын хуулийн талаар илүү сайн ойлголттой, нягтлан бодох бүртгэлийн мэдлэг чадвар сайтай байдаг. Тэд нар хууль ёсоор татвар төлөгчийг төлөөлөн төрөл бүрийг олон асуудлыг зохицуулдаг. Энэ нь татвар төлөгч болон татварын байцаагчийн ажлын ачааллыг бууруулж, мөн татварын албаны үүрэг болох татвар хураах, шаардлагатай шалгалтыг хийхэд төвлөрдөг үйл ажиллагааг нэг алхмаар мэргэшсэн болгож байна.
- 5. *Сурталчилгааны олон төрлийн суваг:* Япон улс нь татвар төлөх нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэхийн тулд зар сурталчилгааны олон сувгийг ашигладаг. Сонин сэтгүүл, телевиз, радио зэрэг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилгаа хийхээс гадна төрөл бүрийн зурагт хуудас, татварын хуультай холбоотой ном зэргийг олон тоогоор хэвлэн тараадаг байна. Мөн жил бүрийн 11-р сард Япон улс нь үндэсний хэмжээнд татварын сурталчилгааны долоо хоногийг зохион байгуулдаг. Эдгээр арга хэмжээ нь Япон улсын татварын хууль, татварын төлөөллийн үйлчилгээний мэдлэгийг олон нийтэд илүү сайн таниулдаг.

Герман улсын татвар төлөгчдийн 90 хувь нь татварын зөвлөх үйлчилгээ авдаг⁶

Герман улс нь 1930-д онд “Татварын төлөөлөх зөвлөхийн хууль”, хамгийн анхны татварын төлөөлөлд тусгайлан хууль гаргасан орон юм. Энэхүү хуульд хуульч, мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн аудит мөн нөхцөл шаардлагад тохирсон татварын туслагч (татварын зөвлөх үйлчилгээ буюу татварын зөвлөх) нар татварын

⁶ 涉税服务在世界各国的发展, 中国税务报·祝穗观

төлөөлөх зэргийг хүргэж болно гэсэн байдаг. 1961 онд Герман улс нь “Татварын төлөөлөх зөвлөхийн хууль”-г засварлан “Татварын төлөөлөгчийн хууль” болгож албан ёсоор татварын төлөөлөгчийг бий болгосон байна.

Хуулийн заалтын дагуу татварын зөвлөх компани байгуулахад заавал Сангийн яамнаас зөвшөөрөл авч бүртгүүлэх ёстой. Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа ажилтан нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, шалгалтаар эрх авсан байх шаардлагатай. Тухайн улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй ажилтан татварын зөвлөх үйлчилгээ үзүүлж болохгүй, хэрэв үзүүлвэл хууль зөрчсөн гэж үздэг байна.

Герман улсын татварын зөвлөх байгууллагууд нь байнгын татварын зөвлөх үйлчилгээнээс гадна тухайн хүний хүсэлтийн дагуу дараах үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Тухайн хүнийг хуулийн маргаанд төлөөлөх, татвар төлөгчийн санхүүгийн тайланг гаргах, төлөөлөн татвар төлөх, нэг удаагийн үл хөдлөх хөрөнгө борлуулалтыг төлөөлөх, өв залгамжлахтай холбоотой асуудлыг төлөөлөх мөн компани дампуурснаас дараах ажлыг зохицуулах, эд хөрөнгө бэлэглэх асуудлыг шийдвэрлэх, эд хөрөнгийн үнэлгээ, компаний үйл ажиллагааны удирдлагад зөвлөгөө үзүүлэх, тухайлбал: хөрөнгө оруулалтын эрсдэлийг үнэлэх, өртөг үнэлэх, санхүүгийн асуудлаар шийдвэр гаргах зэрэг юм.

Герман улсын татварын зөвлөх үйлчилгээний систем нь Япон улстай төстэй. Герман улсын татварын зөвлөх үйлчилгээний ажлын хөлсийг ямар хэмжээтэй байхыг хуулийн заалтаар тодорхой зааж өгсөн байдаг.

Солонгос улсад: ТИЗ-с үйлчилгээ авбал 10%-ийн татварын урамшуулал эдэлж болно⁷.

Солонгос улсын татварын зөвлөх үйлчилгээ нь 1960-аад оноос эхэлсэн. Тэр үед эдийн засаг хурдтай хөгжиж, бизнесийн байгууллага их хэмжээгээр нэмэгдэж, татварын алба их хэмжээний татвар хураалтын ажлыг хүлээж авахад хэцүү болсон. Энэхүү нөхцөл байдалд татвар төлөгч нь татварын нарийн төвөгтэй асуудлыг даван туулахад хүндрэлтэй байсан. Тиймээс Солонгос улс нь 1961 онд татварын системийн өөрчлөлт хийж, мөн оны 9 сард “ТИЗ хууль” гарган хууль баталснаар ТИЗ системийг бий болгосон байна.

Одоогийн байдлаар, Солонгос улсын татварын зөвлөх үйлчилгээний нь цар хүрээний хувьд үндсэн хамгийн түгээмэл үйлчилгээ нь:

- татварын тайланг төлөөлөн тушаах;

⁷ <http://www.chinaacc.com/>, 涉税服务在世界各国的发展, 中国税务报·祝穗观

- татварын зохицуулалтын тооцоо болон холбогдох татварын материал;
- бичиг баримт зэргийг боловсруулах;
- татварын тайлантай холбогдолтой бүртгэл;
- татвартай холбоотой хэлэлцээр эсвэл зөвлөгөө явуулах;
- татварын хяналт шалгалтад татвар төлөгчийг төлөөлөх, тайлбар хийх;
- татварын эрсдэл тодорхойлох, татварын тайланг тодорхойлох юм.

Солонгос улсад татварын төлөөлөгч нь заавал шалгалт өгч ТИЗ эрх авах ёстой. ТИЗ шалгалтыг Улсын татварын албаны шалгалтын алба хариуцан жилд 2 удаа авдаг байна. Мэргэшсэн нягтлан бодогч, хуульч нь татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ заавал сургалтад хамрагдах ба татварын нийгэмлэг энэхүү үйл ажиллагааг хариуцан явуулдаг байна.

Солонгос улс нь ТИЗ –ийн гүйцэтгэх үүрэгт их ач холбогдол өгдөг.

- татварын хууль боловсруулахдаа ТИЗ нийгэмлэг болон ТИЗ-ийг оролцуулж саналыг нь авдаг.
- татварын хуулийн сурталчилгаа нь ихэвчлэн ТИЗ-өөр дамжин хэрэгждэг, ТИЗ нь татвар төлөгчийг үнэн зөвөөр татвар төлөхөд нөлөөлдөг.
- татвар төлөгчдөд татварын хяналт шалгалт хийхэд ТИЗ нь төлөөлж, тайлбар хийх замаар хяналт шалгалтанд туслах үүрэгтэй байдаг.

Солонгос улс нь 1962 онд ТИЗ-ийн нийгэмлэг байгуулсан. Улс даяар ТИЗ-ийн холбоо болон зөвлөлийг байгуулсан. Нийгэмлэг нь хуулийн дагуу нийгэмлэг холбооны дотоод дүрмийг боловсруулдаг ба салбар нь өөрийгөө удирддаг. Энэ нь Япон улсын ТИЗ холбооноос ялгаатай юм.

Солонгос улсын татварын албанаас ТИЗ-өөр тайлангаа хийлгэсэн жижиг дунд аж ахуй нэгжид татвараас 10%-н хөнгөлөлт эдлэх боломжийг олгодог байна⁸. Үүнээс харахад Солонгос улсын ТИЗ нь засгийн газрын бодлого болон хууль дүрмийн ачаар хурдтай хөгжиж байгаа төдийгүй улсын татварын албанаас төрөл бүрийн арга замаар дамжуулан ТИЗ-ийн нийгмийн байр суурь итгэлцлийг нэмэгдүүлж салбарын эрүүл хөгжлийг дэмждэг.

Америкийн Нэгдсэн улсын татварын мэргэшсэн үйлчилгээ нь засгийн газраас хүлээн зөвшөөрсөн цорын ганц татварын мэргэжилтэн юм.

⁸ “税务研究”2005 年第 11 期

Америк улсад 1966 оны 8 сард батлагдсан “Америк улсад үйл ажиллагаа явуулдаг хуульч, мэргэшсэн нягтлан бодогч, татварын мэргэшсэн, аудит тухай ”⁹ дүрэм:”Хуульч, мэргэшсэн нягтлан бодогч, татварын мэргэшсэн, аудит” нь татварын төлөөлөгч хийж болно гэж заасан. Үүнд татварын мэргэшсэн нь заавал шалгалт өгч эрхээ авах, шалгалтыг Улсын дотоод орлогын газар хариуцна гэсэн байдаг. Шалгалтанд тэнцэж бүртгүүлсний дараа татварын зөвлөх үйлчилгээ үзүүлж болно.

Америк улсад татварын тайлан бэлтгэх болон татварын зөвлөгөө өгөх нь татварын мэргэжилтний төвлөрсөн хэлбэрийн үйлчилгээ биш юм. Зарчмын хувьд хүн болгон энэхүү үйлчилгээг үзүүлж болно.

Америк улс нь холбооны, мужийн, орон нутгийн гурван татварын систем хэрэгжүүлдэг учир татварын хууль нь маш нарийн төвөгтэй, журам заалтууд их, мөн татварын хууль зөрчсөн үйлдэлд хатуу шийтгэл оногдуулдаг. Иймээс татвар төлөгчдийн ихэнх нь татварын төлөөлөгчөөр дамжуулан татвар төлөх үүргээ биелүүлдэг. Америк улсад бизнесийн аж ахуй нэгжийн 50-аас дээш хувь нь татварын төлөөлөгчөөр дамжуулан татварын асуудлаа шийдвэрлэдэг байна.¹⁰

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь 1996 оноос эхлэн ТИЗ системийг хэрэгжүүлж эхэлсэн.¹¹ ТИЗ-ийн салбарын хяналтыг сайжруулах зорилгоор татварын албанаас 2006 онд “ТИЗ менежмент завсрын арга хэмжээ” дүрэм баталсан. Энэхүү дүрэм нь ТИЗ шалгалт, эрх үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ, татварын фирм, ТИЗ нийгэмлэг, мөн шийтгэлийн талаар оруулсан байна.

БНХАУ-ын татварын зөвлөх үйлчилгээний бусад хөгжингүй улс оронтой харьцуулбал хөгжлийн эхэн үедээ явж байна. Одоогийн байдлаар БНХАУ-ын татварын төлөөлөлтэй холбоотой хууль тогтоомж ихэвчлэн татварын хэлтсийн дүрэм журам, үр нөлөө бага, эрх мэдэл хангалтгүй байна. Мөн татварын төлөөллийн мэргэжлийн ёс зүй, татварын мэргэшсэн нийгэмлэг, татварын төлөөлөгч дүрэм журам зөрчсөний шийтгэл, татварын фирм дотоод зохион байгуулалт зэрэг нь тусгайлсан хуульгүй байна.

2014 оны 8-р сарын 12-нд БНХАУ-ын засгийн газраас “Захиргааны тусгай зөвшөөрөл зэрэг зүйлсийг цуцлах ба тохируулах шийдвэр” гаргасан, үүнд ТИЗ зөвшөөрлийг цуцлах тухай тодорхой дурдсан.¹² Гэхдээ энэхүү шийдвэр гарснаар татварын зөвлөх

⁹ Treasury Department Circular No. 230 (Rev. 6-2014)

¹⁰ <http://www.chinaacc.com/>, 涉税服务在世界各国的发展, 中国税务报·祝穗观

¹¹ <http://news.xinhuanet.com/politics> 税务总局出台《注册税务师管理暂行办法》

¹² <http://www.chinaacc.com/zhuceshuiwushi> 国务院《国发〔2014〕27号》出台对注册税务师行业的影响分析

үйлчилгээний салбарыг үгүйсгэж байгаа хэрэг биш юм. Харин шийдвэр 2015 оноос хэрэгжиж эхэлсний дараа татварын зөвлөх үйлчилгээний стандартыг нэгдсэн горимд оруулах шаардлагатай хууль дүрмийг боловсруулах зэрэг хууль эрх зүйн асуудлуудыг хийж эхэлнэ.

Олон улсын туршлагаас харахад төр засаг нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг чухалчилж үздэг болох нь энэхүү үйлчилгээг хэрхэн дэмжиж байгаагаас харагдаж байна. Төр нь татварын хуулийг үнэн зөвөөр сурталчлах гол суваг нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ гэж үзэж байна. Татвар төлөгч нь татвар төлөх эрх үүргээ ухамсарладаг, энэхүү үүргээ мэргэжлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж хэвшсэн байна. Ингэснээр татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ нь төр болон татвар төлөгчийг холбох гол гүүр болж байна. ТМЗҮ-ний оролцоог татварын үйл ажиллагаанд оновчтой хослуулж, дэмжсэнээр татвар хураалтын зардал багасч, үр ашиг нэмэгдэж байгаа бол нөгөө талаар татвар төлөгчийн татварын эрсдэл буурч, цаг хугацааг хэмнэж байна.

I. МОНГОЛ УЛСЫН ТМЗҮ-НИЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Манай орны хувьд татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал ямар байгааг дараах судалгаанаас харж болно. Монгол улс нь татвараа өөрөө тодорхойлж төлөх системийг хэрэглэдэг.

Монгол Улсын Үндэсний Татварын Алба:


- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Улс орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Үндэсний Татварын Алба нь Татварын Ерөнхий Газар, Улсын Төсвийн Орлогын Хяналтын Газар, Нийслэлийн Татварын Газар, аймаг, дүүргүүдийн татварын газрууд, сумдын татварын улсын байцаагч гэсэн тогтолцоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсын 2013 оны төсвийн орлогын 91 хувь нь татварын орлого, 9 орчим хувь нь татварын бус урсгал орлогоос бүрдэж байна.¹³

Зураг 2: Төсвийн урсгал орлогын хэмжээ

¹³ А.Батпүрэв, 2013 оны төсвийн төслийн тойм судалгаа- үнэлгээ



Зураг 3: Татварын орлогын бүтэц



Татварын орлогын 30 хувийг Нэмэгдсэн өртгийн албан татвар орлого бүрдүүлдэг. Дэлхийн эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнуудад төсвийн нийт орлогод хувь хүний орлогын албан татварын эзлэх хувийн жин өндөр, хөгжиж буй орнуудад төсвийн нийт орлогод аж ахуй нэгжийн орлогын албан татвар эзлэх хувийн жин өндөр, буурай хөгжилтэй улс орнуудад төсвийн нийт орлогод нэмэгдсэн өртгийн орлогын албан татварын эзлэх хувийн жин өндөр байдаг бөгөөд буурай хөгжилтэй улс орнуудын хувьд ард түмэндээ татварын дарамтыг илүү ихээр үүрүүлдэг гэсэн олон улсын судалгаа байдаг.

Хүснэгт 1: Монгол улсын татвар төлөгчдийн мэдээлэл (2008-2013)

Дэлгэрэнгүй	Татвар төлөгчийн тоо	Утсаар зөвлөгөө өгсөн тоо	%	Хяналт шалгалтанд орсон ААН тоо	%	Зөрчил гаргасан ААН тоо	%

2008	67165	4184	6%	8506	13%	7020	83%
2009	74434	6531	9%	11729	16%	9327	80%
2010	83300	21256	26%	12504	15%	10083	81%
2011	95995	30333	32%	12954	13%	10644	82%
2012	109960	50199	46%	11291	10%	9783	87%
2013	126844	44278	35%	13520	11%	12082	89%
	26%			13%		83%	

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

2008-2013 онд нийт аж ахуй нэгжийн дунджаар 13 хувь нь хяналт шалгалтанд хамрагдсан, эдгээр аж ахуй нэгжийн дунджаар 83 хувь нь зөрчилтэй гаргасан байна. Үүнээс харахад татвар төлөгчдийн татвараа өөрөө тодорхойлон төлөх нийгэм-сэтгэлзүй хангалттай төлөвшөөгүй гэж хэлж болохоор байна. Мөн Татварын албанаас үзүүлдэг утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг 2008-2013 онд дунджаар нийт ААН-ийн 23 хувь авсан байна. Татвар төлөгчид зөвлөгөө авах, мэдээллийн эргэх холбоо сул байгаагаас үүдэлтэй зөрчлүүд татварын албаны ачааллыг нэмэгдүүлж, татвар төлөгчдийн татварын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Татварын үйл ажиллагаанд төр, татвар төлөгчөөс гадна татварын хуулийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх бусад байгууллага, иргэний оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Манай улсад Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ бий болоод удаагүй байна. Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг нь 2004 оны арван хоёрдугаар сарын 23-нд “Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч зөвлөхүүдийн-ТИНЗ нийгэмлэг” нэртэйгээр Сангийн яам, ТЕГ, Аудитын болон бизнесийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачдын санаачлагаар үүсгэн байгуулагдсан.

2012 оны 12 сарын 25-нд “Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль” батлагдсанаар эрх зүйн орчин баталгаажиж, хуулийн хүрээнд нэрээ Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг болгон өөрчилсөн.

2014 оны байдлаар татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 28¹⁴ компани үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсад Япон, Герман зэрэг улсуудтай харьцуулахад ТМЗҮ-ний хугацааны хожуу эхэлсэн хэдий ч хууль-эрх зүйн орчин, нийгэмлэг, боловсон хүчин, зах зээл нь бүгд бүрдэж чаджээ.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ өндөр хөгжсөн орнуудын туршлагаас харахад татвар төлөгч нь өөрийн татвар төлөх үүргийг ухамсарладаг, түүний ач холбогдлыг

¹⁴ www.cpta.mn

мэддэг, татвар төлөх нийгэм-сэтгэлзүйн төлөвшил нь хөгжиж буй орнуудыг бодвол өндөр байдаг. Мөн төвлөрсөн хэлбэрийн татварын зөвлөх үйлчилгээтэй орнуудын хувьд ТМЗ үйлчилгээний ач холбогдлыг маш чухал гэж үзэн төрөөс дэмжлэг үзүүлдэг. Манай улсын хувьд татвараа өөрөө тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтэд татвар төлөгчдийг дадлагажуулах, төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах, ТМЗҮ-г хөгжүүлэхэд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх замаар татвар үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хүснэгт 2: ТМЗҮ-ний 2010 онд тулгамдаж байсан асуудал 2014 онд (харьцуулсан судалгаа)

№	2010	2014
1	Хууль эрх зүйн орчин нөхцөл бүрдээгүй	Тусгайлсан хуультай болсон
2	Татвар төлөгчдийн хуулийн мэдлэг хангалтгүй	Хангалтгүй хэвээр
3	Мэргэшсэн зөвлөх үйлчилгээ хөгжиж эхэлсэн	ТМЗҮ-г хуулийн этгээд гүйцэтгэх болсон
4	Татвар төлөх нийгмийн сэтгэлгээг төлөвшүүлэх асуудал системгүй	Төлөвшөөгүй байна

Эх сурвалж: Япон-Монголын ТИНЗ бага хурал 2010 он

Өнөөгийн нөхцөл байдлаас харахад эхний ээлжинд татвар төлөгчдийн нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.

Бид энэхүү судалгааг татварын албаны чиг үүрэг, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний зарчим, хамрах хүрээ, хуулиудыг харьцуулах замаар “ТМЗҮ-Татварын алба”-ны цаашдын уялдаа холбоотой татварын үйл ажиллагаан дахь хамтын оролцоог тодорхойлов.

ТМЗҮ-ний хуулийн зарчим:

1. бие даасан, хараат бус байх;
2. хуулийг дээдлэн, сахих;
3. үйл ажиллагаагаа шударгаар явуулах;
4. мэргэжлийн ёс зүйг баримтлах;
5. хуулийн хүчин төгөлдөр баримт бичигт үндэслэх;
6. үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
7. мэдээллийн нууцыг хадгалах

8. эрх тэгш байх гэсэн зарчмыг баримтлан ажиллана гэж заасан байдаг. Энэ нь татварын алба (2,3,4,5), татвар төлөгч (1,6,7,8) хоёрын ашиг сонирхлыг холбох гүүр гэдэг нь харагдаж байна. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ нь хоёр өөр эрх ашиг бүхий талуудыг холбож байна.

Дараах хүснэгтэнд татварын алба болон татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний чиг үүргүүдийн нэгдэлийг харуулав.

Хүснэгт 3: Татварын алба, ТМЗҮ-ний уялдаа

Татварын алба	Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ
1. Ил тод, нээлттэй, шуурхай, үйлчилгээнд чиглэсэн байх	1. Татварын тухай хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн туслалцаа үзүүлэх
2. Орлогоо бодитойгоор мэдүүлж, татвар төлөлтийг нэмэгдүүлэх	2. Татварын тухай хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сурталчлан таниулах

Татварын алба нь ил тод, нээлттэй, шуурхай үйлчилгээнд чиглэсэн байхын тулд татварын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах шаардлагатай. Сурталчлан таниулахын тулд ТМЗҮ бүхий байгууллагаар дамжуулан мэргэжлийн туслалцаа үзүүлэх хэрэгтэй. Учир нь татварын алба татвар хураах, төсвийн орлого бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, татвар төлөгчдөөс орлогоо бодитойгоор мэдүүлэхийг шаарддаг. Энэ нь манай орны татвараа өөрөө тайлагнах нийгэм-сэтгэлзүйн төлөвшил бүрдээгүй байгаа орны хувьд далд хардалтын зан байдал татвар төлөгчдөд төрүүлдэг.

Хүснэгт 4: Татварын алба, ТМЗҮ-ний чиг үүргийн хоорондын уялдаа холбоо

Үндэсний татварын албаны чиг үүрэг	Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ
1. Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөлгөө өгөх, <i>сургалт, сурталчилгаа явуулах</i> ; 2. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; 3. Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх. Татварын алба, татварын улсын байцаагч хууль тогтоомжоор тодорхойлсон татвар төлөх үүргээ биелүүлэхэд нь татвар төлөгчид тусалж дараахь үйлчилгээг үзүүлнэ:	I. Татварын тухай хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан <i>мэргэжлийн туслалцаа үзүүлэх, сурталчлан таниулах</i> ; II. Хууль тогтоомжийн дагуу татварын тооцоо, тохируулга хийх, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтын бүрдлийг хянах, татварын нөлөөллийг бүртгэх, батлагдсан маягтын дагуу татварын тайланг гаргах; III. Үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг

<ol style="list-style-type: none"> 1. Татварын хууль тогтоомжийг <i>тайлбарлан таниулах</i>; 2. Татварын хууль тогтоомжийг нэг мөр дагаж мөрдөх, татварын үүргээ тодорхойлох, тайлан, мэдээ гаргахтай холбогдсон <i>заавар, аргачлал, гарын авлага, маягтаар хангах</i>; 3. Татварын хууль тогтоомж, заавар, аргачлалын талаар сургалт зохион байгуулах; 4. Татварын үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлаар татвар төлөгч хэсгээрээ буюу <i>ганцаарчлан зөвлөлгөө авах боломжийг бүрдүүлэх, тийм зөвлөлгөө өгөх</i> 5. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, татварын албаны цахим хуудсаар дамжуулан нийтийг хамарсан <i>сурталчилгаа, сургалт, мэдээллийн нэвтрүүлэг зохион байгуулах, нийтлэл гаргах</i>. 	<p>гаргах;</p> <p>IV. Татварын алба, холбогдох бусад этгээдтэй үйлчлүүлэгчийг <i>төлөөлөн харилцах</i>.</p>
---	--

Татварын алба, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэх үүрэг, чиглэлийг харахад:

- татварын хуулийг танин мэдүүлэх, суртчилан таниулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэсэн ерөнхий чиглэлээр ашиг сонирхол нь нэгдэх замаар татварын үйл ажиллагаан дахь татвар төлөгчдийн нийгэм-сэтгэлзүйн төлөвшлийг бүрдүүлэх боломжтой юм.

Татвар хураалтын тасаг: Татвар төлөгч(аж ахуй нэгж байгууллага)-д

- Татварын хууль тогтоомж, заавар журам, аргачлалыг тайлбарлан таниулах, сурталчилах, зөвлөлгөө өгөх
- Сургалт сурталчилгааг татвар төлөгчдийн дунд зохион байгуулах, гарын авлагаар хангах
- Татварын бааз суурийг өргөтгөн татварт хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх
- Татварын тайланг стандартад хүргэн, ирцийг хангуулах
- Татвар хураалтын түвшинг нэмэгдүүлэх, өрийн барагдуулалтыг сайжруулах, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэх, татвар хураалтын үйл ажиллагааг боловсронгуй болгоход оршино.

Татварын албаны нэг цэгийн үйлчилгээ¹⁵: Мэдээллийг татвар төлөгчдөд хүргэх хэлбэр нь дараахь байдалтай байна. Үүнд:

- самбар
- нои, эмхтгэл, гарын авлага
- компьютерийн мэдээллийн сан
- вэб хуудас

Татвар төлөгчдөд хууль тогтоомж аргачлалыг тайлбарлан таниулах, зөвлөгөө өгөх , мөн сургалт сурталчилгаанд ТМЗҮ-ний оролцоог нэмэгдүүлж болно.

ДҮГНЭЛТ

Татвараа өөрөө тодорхойлон төлөх систем нь татвар төлөгч хуулийн дагуу татвараа тооцох, бүртгэх, тайлагнах ажлыг гүйцэтгэх хэрэгцээ гардаг бол татварын алба нь татварын хуулийг татвар төлөгч шударгаар хэрэгжүүлж буйг хянах хэрэгтэй болдог. Татвар хураах үйл ажиллагаа нь татварын албаны үүрэг, татвараа төлөх нь татвар төлөгчийн үүрэг байдаг ч татвар төлөгч татвараа хэрхэн тооцож ногдуулах мэдлэг арга зүй дутах, татвар төлөгчийн тайлан мэдээлэл үнэн зөв эсэхийг хянах боломжгүй байх зэргээс татварын үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг.

Татвар төлөгч нь татварын хуульд заасан үүрэгээ цаг тухайд нь биелүүлж байгаа эсэх нь татварын үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлнэ. Татвар төлөх үүргээ сайн биелүүлэх нөхцөл¹⁶:

- Татвар төлөгчийн татварын хуулийн талаарх мэдлэг сайн
- Татвар төлөгчийн татварын хуулийн хүлээн зөвшөөрөлт
- Татварын хуулийг зөрчих нь том эрсдэл дагуулна гэдгийн ойлгох юм.

Татвар төлөгчийн татвар төлөх үүргийн биелэлтийг сайжруулах үндсэн арга зам¹⁷:

- Татвар төлөгчийн үүргийг тодорхой болгох
- Биелүүлэхэд илүү хялбар болгох
- Шаардлагатай тохиолдолд хориг арга хэмжээг авах
- Өөрийн хүч болон үйл ажиллагааг харагдахуйц болгох- таниулан суртачилах
- Урамшуулал олгох

¹⁵ <http://www.nta.mn/>

¹⁶ <http://wiki.mbalib.com>

¹⁷ OECD, 2004, Compliance Risk Management: Managing and Improving Tax Compliance

Татварын алба дангаараа татвар төлөгчийн татвар төлөх үүргийн биелэлт болон нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэх нь зардалын хувьд өндөр мөн бүх татвар төлөгчидөд хүрч ажиллах боломжгүй юм. Нөгөө талаас ТМЗ нь татвар төлөгчийг татвараа төлөх болон татварын үүргийн биелэлтэнд эерэг нөлөөлөл үзүүлдэг байна. (Roman Tomasic, 1990) Олон улсын туршлагаас харахад Татвар төлөгч-ТМЗҮ-Татварын албаны уялдаа холбоог сайн хангаж чадсанаар татварын үйл ажиллагаа нь илүү боловсронгуй болох, татварын хуулийг таниулан суртчилах зэрэг ажлууд илүү үр дүнтэй байдаг байна.

Манай орны хувьд энэхүү гурвалсан харилцааны уялдааг илүү сайжруулах шаардлага байна. Тухайлбал:

1. Татварын албаны дэмжлэг-ТМЗҮ
2. ТМЗҮ-ний нөлөөлөл- Татвар төлөгч
3. Татвар төлөгчдийн татварын боловсролыг нэмэгдүүлэх, сурталчилах гэсэн 3 хүрээнд түлхүү ажиллах хэрэгцээ байна.

V. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Татварын албаны дэмжлэг ба ТМЗҮ-ний оролцоо:

Татварын алба болон ТМЗ үйлчилгээ нь татварын хуулийг танин мэдүүлэх, суртчилан таниулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэсэн ерөнхий чиглэлтэй. Татварын хуулийг суртчилан таниулах нь урт хугацааны байнгын давтамжтай хийгдэх үйл ажиллагаа юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн давуу талыг бүрэн дүүрэн ашиглаж, телевиз радио, сонин сэтгүүл, зурагт хуудас зэргээр дамжуулан татварын философийг тод томруун уриа болгох нийгэмд түгээх хэрэгтэй. Энэхүү урт хугацааны үйл ажиллагаанд ТМЗҮ-ний оролцоог нэмэгдүүлсэнээр нэг талаас татварын албаны үйл ажиллагаанд дэмжлэг болно, нөгөө талаас ТМЗҮ нийгэмд илүү танигдах боломжтой юм.

1. Татварын тайлан тушаах хугацаа эхлэх буюу дуусах хугацаанд ТМЗ байгууллага болон олон нийтийн сайн дурын байгууллагуудтай хамтран татварын тайлан гаргах талаарх заавар зөвлөмжийг үнэгүй хүргэж байх
2. Зөрчилтэй ААН-д татварын алба нь ТМЗҮ-г танилцуулах, татварын албан хаагчдад ТМЗҮ-ний ач холбогдолын талаар мэдээлэл өгөх, нэгдсэн нэг мэдээлэлтэй байх
3. Хамтран татварын орчны судалгаа хийх, ТМЗҮ-ний нэр хүндийг нийгэмд нэмэгдүүлэх, ач тусыг ойлгуулах

Татвар төлөгчдийн нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхийн тулд:

Татвар төлөгчийн татвар төлөх нийгмийн сэтгэлзүйн төлөвшүүлэхийн татвар төлөгчдийг сегментчилэх хэрэгтэй гэж үзсэн байдаг. (McBarnet, 2001)¹⁸

Энэхүү сегментчлэлийн дагуу өөрсдийн судалгааны ажил дээр үндэслэн цаашид татвар төлөгчдийн нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх ямар боломж байгааг тодорхойллоо.

Хүснэгт 4: Татвар төлөгчдийн нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх арга зам

Үйл явц	Тууштай дагаж мөрдөх	Зайлшгүй дагаж мөрдөх	Бүтээлчээр дагаж мөрдөх
Төрийн оролцоо	Татварын албанаас нөлөөлөх нөлөөлөл багатай	Татварын албаны нөлөөлөх нөлөөлөл ихтэй	Татварын албаны эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх
Зан төлөв	Шийтгэлээс айх биш үүнийг хийх нь зөв зүйл гэдэгт итгэх	Шийтгэлээс айх, хэрэгжүүлэх ёстой гэсэн зан төлөв	Шийтгэлээс айх биш өөртөө хөрөнгө оруулалт хийж буйг ухамсарлах зан төлөв
Нөлөөлөл	Нийгмийн бүлгүүдийн харилцаагаар дамжуулах	Төрийн оролцоогоор нөлөөлөх	Бүтээлч, үр дүнтэй харилцааг бүрдүүлэх
Үйл ажиллагаа	Боловсролын системээр нэвтрүүлэх	Мэдээллийн нээлттэй тайлагналын системийг бүрдүүлэх	Гөрөөс ТББ-ыг дэмжин ажиллах тогтолцоог сайжруулах
Үр дүн	Татвар төлөх нийгмийн сэтгэл зүй төлөвшсөн байна.	Хариуцлагын хатуу чанга тогтолцоог бий болсон байна. Татвар төлөх ухамсар нэмэгдсэн байна.	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэхэд ТМЗҮ-ний оролцоог нэмэгдэж ирнэ.

Татвар төлөгчдийг нэг хэв маягийн хүмүүсээр ойлгохоос татгалзаж, харин татвар төлөгчдөө зан төлөв, үзэл баримтлалаар нь сегментчилэн тэдний онцлого шинжүүдэд нь тохирсон нөлөөллийн үйл ажиллагааг явуулах нь зүйтэй гэдэг нь харагдаж байна .

¹⁸ McBarnet, D., 2001. *When compliance is not the solution but the problem: From changes in law to changes to attitude.* Canberra: Australian National University, Centre for Tax System Integrity

Ашигласан эх сурвалж:

1. OECD Tax Intermediaries Study Working Paper 6 – The Enhanced Relationship
2. Organization for Economic Co-operation and Development (OECD), Taxpayers’ Rights and Obligations—Practice Note (2001).
3. Harry L.Gutman , The Role of the Tax Advisor in the Changing World of Global Tax Administration
4. McBarnet, D., 2001. When compliance is not the solution but the problem: From changes in law to changes to attitude. Canberra: Australian National University,
5. Roman Tomasic and Brendan Pentony, 1990, Defining acceptable tax conduct: the role of professional advisers in tax compliance
6. Г.Алтанзаяа, Татвар хураах механизм, Бодлогын судалгаа- 2007
7. А.Батпүрэв, 2013 оны төсвийн төслийн тойм судалгаа- үнэлгээ
8. Х.Тунгалагмаа, Монгол улсын татвар төлөлтийн төлөвшилтөд татварын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэх үүрэг
9. Х.Тунгалагмаа, Татварын зөвлөх үйлчилгээний олон улсын туршлагаас суралцах боломж
10. Монголтакс, Татварын ерөнхий газар, Монгол улсын татварын статистик-2012
11. Х.Тунгалагмаа, Х.Өлзийтунгалаг, Б.Сарнай, Б.Хонгорзул, Олон улсын татвар төлөгчдийн загвар- 2013 орчуулга
12. 税务研究”2005 年第 11 期
13. <http://www.chinaacc.com/>, 涉税服务在世界各国的发展, 中国税务报·祝穗
14. <http://news.xinhuanet.com/politics> 税务总局出台《注册税务师管理暂行办法》
15. <http://www.chinaacc.com/>国务院《国发〔2014〕27 号》出台对注册税务师行业的影响分析
16. <http://www.irs.gov> Treasury Department Circular No. 230 (Rev. 6-2014)
17. <http://www.mta.mn/news/show/482>
18. www.cpta.mn
19. www.legalinfo.mn